

## “БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 18/22

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь заалт, 61 дугаар зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.15 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн 2022 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, “Булигаар” ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - 2.1. Компанийн зарласан хувьцаанаас нэмж гүйлгээнд гаргах тоог тогтоох, ТУЗ-д эрх олгох;
  - 2.2. Компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ батлах, хувьцааны тоог тогтоох;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2022 оны 08 дугаар сарын 22, 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд өдөр тутмын сониноор тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт №2-оор баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2022 оны 9 дүгээр сарын 23-ны 14.00 цаг хүртэл байна.

6. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1, Хавсралт №2 дахь мэдээлэл болон компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт тус тус хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичгийг 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
8. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар А.Энхмэндийг, мөн хурал зохион байгуулах комиссын даргаар Ц.Мөнхлхагва, гишүүдэд Н.Тэмүүжин, О.Сүнжидмаа нарыг сонгосугай.
9. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилон байгуулсугай.  
Тооллогын комиссын дарга: Ю.Дүгэрмаа  
Тооллогын комиссын гишүүд: Д.Энхзул, Б.Саруул
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материал, баримт бичигтэй ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Анхболд-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД